

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР



**ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН  
САНГИЙН 2024 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ  
ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА**

УЛААНБААТАР ХОТ

2023 ОН



## ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН САНГИЙН 2024 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Эрүүл мэндийн даатгалын сангийн 2024 оны төсвийн орлогыг 2,002.2 тэрбум төгрөг байхаар төсөвлөсөн. Эрүүл мэндийн даатгалын сангийн нийт орлогын 55.4 хувь буюу 1,108.4 тэрбум төгрөгийг Улсын төсвөөс олгохоор тооцсон. Үүнээс Эрүүл мэндийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.6 дахь хэсэгт заасан төр зардлыг нь хариуцах тусламж, үйлчилгээний санхүүжилтэд 767.4 тэрбум төгрөг, Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2.3 дахь заалтад заасны дагуу төр эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг нь хариуцан төлөх иргэдийн шимтгэлийн хэмжээ хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ нэмэгдүүлэхтэй холбогдуулан Улсын төсвөөс олгох шилжүүлгийг 341.0 тэрбум төгрөгөөр тус тус тооцсон. Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд заасан албан журмын болон сайн дурын даатгалын шимтгэлийн орлогыг 893.8 тэрбум төгрөг байхаар төлөвлөлөө.

Эрүүл мэндийн сангийн нийт зарлагыг 1,970.6 тэрбум төгрөг байхаар төлөвлөсөн. Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлөөс баталсан тогтоолд заасан тарифын дагуу тооцож Эрүүл мэндийн даатгалын сангаас худалдан авах тусламж, үйлчилгээний зардалд нийт 1,758.8 тэрбум төгрөг төлөвлөснөөс эрүүл мэндийн анхан шатны эрүүл мэндийн байгууллагад нэг иргэнээр тооцон олгох санхүүжилтийг сумын 391.5 тэрбум төгрөг байхаар тусгасан. Мөн төр хариуцах эмийн зардлын хяналт, хүртээмжийг сайжруулах зорилгоор эмийн үнийн хөнгөлөлтөд олгох санхүүжилтийг нэмэгдүүлж 140.0 тэрбум төгрөг, эрсдэлийн санг 54.9 тэрбум төгрөг, үйл ажиллагааны зардлыг 17.2 тэрбум төгрөг байхаар тус тус тооцлоо.

--- оОо ---



## ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН САНГИЙН 2024 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Эрүүл мэндийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төсөл нь 2 бүлэг, 6 зүйлтэй бөгөөд нэгдүгээр бүлэгт эрүүл мэндийн даатгалын сангийн хуулийн зорилтыг тусгасан бол хоёрдугаар бүлэгт эрүүл мэндийн даатгалын сангийн 2024 оны төвлөрүүлэх орлогын хэмжээ, зарцуулах зарлагын хэмжээ болон эргэн төлөх төлбөрийн хэмжээ тус тус тусгагдсан.

Монгол Улсын Засгийн газар Шинэ сэргэлтийн бодлогын хүрээнд эдийн засгийн өсөлтийг эрчимжүүлэх, төлбөрийн тэнцлийн алдагдлыг бууруулах, гадаад валютын нөөцийг нэмэгдүүлэх, үнийн өсөлтийг хязгаарлаж иргэдийн бодит орлогыг хамгаалах, төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулахад чиглэсэн бодлого, арга хэмжээг үе шаттайгаар хэрэгжүүлж байна.

Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд заасан эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилтыг хангах хүрээнд эрүүл мэндийн байгууллагуудын төсвийг нэг худалдан авагчийн зарчмаар, гүйцэтгэлд суурилсан хэлбэрээр 2021 оноос эхлэн санхүүжүүлж байна.

Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ 2024 онд нэмэгдэхтэй холбоотойгоор Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд заасан улсын төсвөөс хариуцах эрүүл мэндийн даатгалын шимтгэл болон тусламж үйлчилгээний зардал нэмэгдэхээр байна. Түүнчлэн төрийн албан хаагчдын цалин хөлс болон хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэмэгдүүлэх арга хэмжээ, аж ахуй нэгж, байгууллагад ажиллагсдын дундаж цалин хөлсний өөрчлөлттэй уялдуулан эрүүл мэндийн даатгалын сангийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх шаардлага үүсэж байна.

Эрүүл мэндийн сангаас зарцуулах тусламж үйлчилгээний санхүүжилтийг анхан шатны тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, бүс нутгийн онцлогийг харгалзсан ялгаатай байдлаар сумын эрүүл мэндийн төвийн эмнэлгүүдэд олгох, нэн шаардлагатай тусламж үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэхэд түлхүү анхаарахад чиглүүллээ. Мөн эмч, эмнэлгийн ажилтны цалин хөлс, эм, эмнэлгийн хэрэгслийн үнийн өсөлтийг харгалзан эрүүл мэндийн даатгалын сангаас олгох тусламж, үйлчилгээний өртөг, тарифыг өсгөх шаардлага бий болж байна.

### Эрүүл мэндийн сангийн орлого

Эрүүл мэндийн даатгалын сангийн 2024 оны төсвийн орлогыг 2,002.2 тэрбум төгрөг байхаар төсөвлөсөн. Эрүүл мэндийн даатгалын сангийн нийт орлогын 55.4 хувь буюу 1,108.4 тэрбум төгрөгийг Улсын төсвөөс олгохоор тооцсон. Үүнээс Эрүүл мэндийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.6 дахь хэсэгт заасан төр зардлыг нь хариуцах тусламж, үйлчилгээний санхүүжилтэд 767.4 тэрбум төгрөг, Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2.3 дахь заалтад заасны дагуу төр эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг нь хариуцан төлөх иргэдийн шимтгэлийн хэмжээ хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ нэмэгдүүлэхтэй холбогдуулан Улсын төсвөөс олгох шилжүүлгийг 341.0 тэрбум төгрөгөөр тус тус тооцсон. Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд заасан албан журмын болон сайн дурын даатгалын шимтгэлийн орлогыг 893.8 тэрбум төгрөг байхаар төлөвлөв.

Д/д	Орлогын төрөл	Дүн /сая тогроогоор/
1	<b>Эрүүл мэндийн сайд</b>	<b>2,002,198.9</b>
	1.1 Ажил олгогч, даатгуулагчаас төлөх шимтгэл	859,154.8
	1.2 Төрөөс эрүүл мэндийн даатгалыг нь хариуцах иргэдийн улсын төсвөөс төлөх шимтгэл	341,006.1
	1.3 Төр хариуцах тусламж, үйлчилгээний санхүүжилт	767,353.3
	1.4 Бусад даатгуулагчаас төлөх шимтгэл	34,684.8
	<b>Нийт орлого</b>	<b>2,002,198.9</b>

### Эрүүл мэндийн сангийн зарлага

Эрүүл мэндийн сангийн нийт зарлагыг 1,970.6 тэрбум төгрөг байхаар төлөвлөсөн. Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлөөс баталсан тогтоолд заасан тарифын дагуу тооцож Эрүүл мэндийн даатгалын сангаас худалдан авах тусламж, үйлчилгээний зардалд нийт 1,758.8 тэрбум төгрөг төлөвлөснөөс эрүүл мэндийн анхан шатны эрүүл мэндийн байгууллагад нэг иргэнээр тооцон олгох санхүүжилтийг сумын 391.5 тэрбум төгрөг байхаар тусгасан. Мөн төр хариуцах эмийн зардлын хяналт, хүртээмжийг сайжруулах зорилгоор эмийн үнийн хөнгөлөлтөд олгох санхүүжилтийг нэмэгдүүлж 140.0 тэрбум төгрөг, эрсдэлийн санг 54.9 тэрбум төгрөг, үйл ажиллагааны зардлыг 17.2 тэрбум төгрөг байхаар тус тус тооцлоо.

Д/д	Зарлагын төрөл	Дүн /сая тогроогоор/
1	<b>Эрүүл мэндийн сайд</b>	<b>1,970,613.2</b>
	1.1 Эрүүл мэндийн даатгалын сангаас хариуцах тусламж үйлчилгээний санхүүжилт	904,939.8

1.2 Төрөөс хариуцах тусламж, үйлчилгээний санхүүжилт	853,846.5
1.3 Эмийн санд олгох	139,982.5
1.4 Үйл ажиллагааны урсгал зардал	17,244.4
1.5 Эрсдэлийн сан	54,600.0
<b>Нийт зарлага</b>	<b>1,970,613.2</b>

--- oOo ---